

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2019 оны V сарын 01-ний өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2019 оны 5 дугаар сарын I долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 25 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 5 нэрийн барааны үнэ **буурсан**, 2 нэрийн барааны үнэ **өссөн** байна. Үүнд:

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил дээд "Алтан Тариа" задгай гурил I "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд "Алтан Тариа" савласан гурил дээд "Алтан Тариа" савласан гурил I "Алтан Тариа" савласан гурил II "Сүү" ХК савласан 0.5 л сүү Сүү, задгай Тараг, Цөцгийтэй Талх, "Атар" Талх, "Зууван чех" Талх, "хөх тарианы хар" Шар будаа Цөцгийн тос, Сүү ХК Ургамлын тос, "Янта" Ногоон цай, "Сtimo" Хонины мах, цул Адууны мах, ястай Ямааны мах, ястай Төмс, монгол Лууван, монгол Байцай, монгол Хүрэн манжин, монгол Сонгино, хятад, бөөрөнхий Алим, фүжи 	<ul style="list-style-type: none"> "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү Элсэн чихэр, "Заантай" Хонины мах, ястай Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул 	<ul style="list-style-type: none"> Цагаан будаа, "Заантай" Өндөг, ОХУ

Махны дундаж үнэ

2019 оны 5 дугаар сарын I долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 8734 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 9599 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 22 төгрөгөөр (0.2%), үхрийн цул махны үнэ 50 төгрөгөөр (0.4%) тус тус буурсан байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8500 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 10000 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг




Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	9 599*							

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	8 734*							

* 1-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 41 төгрөгөөр (0.5%) буурч, харин хонины цул махны үнэ тогтвортой байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 8000 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 9500 төгрөгөөр худалдаалж байна.


Гурилын үнэ

2019 оны 5 дугаар сарын I долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1300-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1300-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Будааны үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг



“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1200-1320 төгрөгийн үнэтэй байна. “Баянзүрх”, “Бөмбөгөр”, “Барс”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1320 төгрөгөөр худалдаалж байна.

Хүнсний ногооны үнэ

2019 оны 5 дугаар сарын I долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад хүнсний ногооны үнэ тогтвортой байлаа.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2019.V.01
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны II, III, IV, V сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2013-2019 оны V сарын 01
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2019.V.01
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны II, III, IV, V сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018-2019 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2019.V.01